

Озоны давхаргаа хамгаалъя

Танин мэдэхүйн мэдээ, мэдээлэл

Хүмүүсийн өдөр тутмын хэрэглэдэг зарим химийн бодис (озон задалдаг бодис)-ууд нь агаарт алдагдсанаар Давхраат мандлын озоны давхаргад нөлөөлж, уг давхарга нимгэрч эхэлснийг 1970аад оноос тогтоож, 1985 онд эрдэмтэд судалж баталгаажуулжээ. Давхраат мандлын озоны давхарга нь Дэлхийн хүн төрөлхтөн, амьд байгалийг сүйтгэх (нүдний болор цайх, арьсны өмөн үү үүсэх гэх мэт) нарны хэт ягаан туяаг өөртөө шингээн биднийг хамгаалдаг болно. Иймд Дэлхийн улс орнууд озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулж улмаар хэрэглээнээс бүрмөсөн халах зорилт тавин ажиллаж озоны давхаргаа хамгаалж байна.


Озоны давхаргын цоорхойн талбайн хэмжээ 1985 онд 14.21 сая км² байсан бол 2006 онд 26.6 сая км²-д хүрч хамгийн ихээр цоорсон болно¹. Озоны молекулыг задлах урвалд озон задалдаг бодисын агууламжаас гадна туйлын маш хүйтэн температур нөлөөлдөг тул агаарын дундаж температур дулаан жилүүдэд озоны цоорхойн талбайн хэмжээ буурдаг байна.

Хэрвээ хүмүүсийн хэрэглээнд (хөргөгч, агааржуулагч төхөөрөмж зэрэг) байгаа озон задалдаг бодисыг үе шаттай бууруулж хэрэглээгээ зогсоовол озоны давхарга нөхөгдөн сэргэх боломжтой юм.


¹АНУ-ын Агаарын нислэг, сансрын уудмыг шинжлэн судлах үндэсний газар (NASA)

Озоны давхаргын цоорхой үүсэх нь


Дэлхийн давхраат мандлын озоны давхарга хэвийн хэмжээндээ хүрэх хугацааг эрдэмтэд XXI зууны сүүлийн хагас гэж тооцоолж байгаа бөгөөд энэхүү эргэн нөхөгдөх үйл явцад дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлс мөн адил нөлөөлнө.




1979 оны 9 сар




1994 оны 9 сар



2006 оны 9 сар



2017 оны 9 сар



Нийт баганын озон
(Добсоны нэгж)

Дэлхийн дулаарлыг сааруулах нь

Нөгөө талаар озон задалдаг бодисууд нь дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (ДДНЧ) ихтэй хүлэмжийн хийнүүд байдаг юм. Тиймээс озоны давхаргыг хамгаалах үйл ажиллагаа нь дэлхийн дулаарлыг сааруулахад мөн хувь нэмрээ оруулдаг байна.

Зөвлөгөө

Озон задалдаг бодисууд нь ихэвчлэн тасалгааны болон автомашины агааржуулагч төхөөрөмж, гэр ахуйн хөргөгч, хөлдөөгч, худалдаа, нийтийн хоолны хөргөх төхөөрөмжүүдэд хөргөх бодис (refrigerant)-ын зориулалтаар ашиглагддаг. Тухайлбал, ахуйн зориулалттай хөргөгчинд агуулагдах хөргөх бодисын хэмжээг дараах зурагт харуулсан техникийн үзүүлэлттэй шошгоноос олж мэдэх боломжтой.



Нийт хэмжээ (Gross volume)	354L	Эрчим хүчний хэрэглээ (Energy consumption)	221W-h/ year
Уур амьсгалын ангилал (Climate classification)	SN- ST	Чадал (Power input)	280 W
Хүчдэл (Rated Voltage)	220~ 240V	Хөргөх бодис (Refrigerant)	R600a 58g
Давтамж (Rated Frequency)	50Hz	Цэвэр жин (Net Weight)	70 kg

Хөргөлт агааржуулалтанд хэрэглэх орлуулах бодис

Хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжид агуулагдах хөргөх бодис агаарт алдагдсан тохиолдолд давхраат мандлын озоны давхарга нимгэрч, мөн адил дэлхийн дулааралд сөрөг нөлөөтэй тул дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхийг иргэд та бүхнээс уриалж байна.

- Хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмж худалдан авахдаа ДДНЧ багатай орлуулах хөргөх бодис агуулсан төхөөрөмжийг сонгох

Бодисын нэр	Бодисын төрөл /Тайлбар	ОЗЧ*	ДДНЧ
R22 (HCFC-22)	Хлор агуулсан озон задалдаг бодис	0.055	1810
R134a (HFC-134a)	ДДНЧ өндөртэй орлуулах бодис	0	1430
R600a (HC-600a)	ДДНЧ багатай орлуулах бодис(байгалийн хөргөх бодис)	0	3
R410A (HFC-32/HFC-125)	Орлуулах бодисын хольц	0	2088

*Озон задлах чадвар (Ozone depleting potential)

- Хөргөгчийг хананаас хөндий байрлуулж, конденсатор байрладаг арын хэсгийг нь тогтмол цэвэрлэж, хөлдөөгчний мөсийг тогтмол хайлуулах;
- Хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмждөө засвар үйлчилгээ хийлгэхдээ мэргэшсэн гэрчилгээтэй техникийн ажилтанд хандах.

Таны тусын тулд

Та үүнийг мэдэх үү?

- Давхраат мандлын озоны давхарга нь жигд бус тархалттай байдаг. Энэ нь тухайн газар нутагт амьдардаг хүн амын арьсны өнгөтэй хэрхэн уялдаатайг судалж үзээрэй.
- Цайвар, цагаан өнгийн арьстай хүмүүс нь нарны хэт ягаан туяаны нөлөөгөөр хар, бор өнгийн арьстай хүмүүсээс илүү арьсны хорт хавдраар өвчлөх эрсдэл өндөртэй байдаг. Энэ нь хүний арьсан дахь меланин пигментийн хэмжээтэй хамаатай юм.
- Агаар мандал дахь озоны молекулын нийт хэмжээг ихэвчлэн Добсоны нэгжээр хэмждэг ба байршил, улирлаас хамаараад гол төлөв 200-500 Добсон нэгж байдаг. 500 Добсоны озон нь газрын гадарга дээр буюу атмосферын даралтад ердөө 5 мм зузаантай озоны хийн бүрхүүл үүсгэнэ.
- Хэрэв та 4,5 кг R-22 бодисыг агаарт алдвал энэ нь Дэлхийн дулааралд 8145 кг CO₂ хий ялгаруулсантай тэнцүү хэмжээний нөлөө үзүүлнэ. Хэрэв суудлын автомашин ойролцоогоор 0.200 кг/км CO₂ хий ялгаруулдаг гэж тооцвол дээрх ялгарал нь автомашинаар 40725 км (дэлхийг нэг бүтэн тойрох) зам туулсантай тэнцэх юм.

Тэмдэглэл хөтлөх

Гэртээ байгаа ахуйн хөргөгч, хөлдөөгч эсвэл агааржуулагч төхөөрөмжид агуулагдаж буй хөргөх бодисын төрөл, массыг төхөөрөмжийн техникийн үзүүлэлтээс олж түүний нийт ДДНЧ буюу CO₂ экв хэмжээг тооцоолоорой.

Хөргөх бодисын төрөл	R-
Хөргөх бодисын хэмжээ	кг
ДДНЧ	
CO ₂ экв	кг

Хөргөх бодисуудын ОЗЧ,
ДДНЧ-ыг интернэтээс болон
дараах гар утасны
аппликейшнээс мэдэх
боломжтой.





**Хандлагаа }
ӨӨРЧИЛЬЕ!**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА**

Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайвны өргөн чөлөө-4, Экспресс цамхаг, 304в тоот

Утас: 312458, 99192160, 88003181

Цахим хаяг: mongolia@ozone.mn

Facebook page: Noa Mongolia, NOA Mongolia